



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлд:

XVIII. ХЭЛЭЛЦСЭН нь:

Гадаадын иргэн, харьяатын газар, түүний харьяа газарт үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны 1-3/656 дугаар албан бичгээр Гадаадын иргэн, харьяатын газарт Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын дэмжлэгээр хүлээн авсан нийт 288,000,000.00 (хоёр зуун наян найман сая) төгрөгийн, 8 ширхэг тээврийн хэрэгслийг бүртгэх саналыг ирүүлсэн.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.5 дахь заалтад "...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр төрийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг хүлээн авч, төрийн өмчид бүртгэнэ" гэж заасны дагуу Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтоол гаргасан нөхцөлд Гадаадын иргэн, харьяатын газар, түүний харьяа газарт үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох асуудлыг дахин хэлэлцэх нь зүйтэй гэж үзэв." гэжээ.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

000293
D:\Huraldaanii material\2018 on\2018.11.20\Temdegel.docx